



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ГАА-2023/28-5-ШТА-ГА



Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр
Утас: 70483413
Цахим хаяг: Tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер Д.Эрдэнэчимэг
Утас: 70484055
Цахим хаяг: Erdenechimegd@audit.gov.mn
Аудитор Ц.Сайханжаргал
Утас: 92116535
Цахим хаяг: Saikhanjargalts@audit.gov.mn
Аудитор М.Атарцэцэг
Утас: 88984411
Цахим хаяг: Atartsetsegm@audit.gov.mn
Аудитор М.Дөлгөөнбаяр
Утас: 85151215
Цахим хаяг: Dulguunbayarm@audit.gov.mn



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ	4
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
А.1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА.	7
А.1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 1 төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан үзэл санаатай нийцэхгүй байна.....	7
А.1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр тайлант онд батлагдсан 1 төсөл, арга хэмжээ нь "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-тэй нийцээгүй байна.....	8
А.1.3. Шинэ суурьшлын бүсэд баригдаж байгаа барилга байгууламжийн дэд бүтцийг бие даасан байдлаар шийдвэрлэж буй нь төлөвлөлтийг хийхдээ баримт бичгийн уялдааг хангахгүй байгааг илтгэж байна.....	8
А.2. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.	9
А.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламж нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой байна.	9
А.2.2. Орон нутагт уг асуудалд дүгнэлт өгөх боломжгүй байна.	9
А.2.3. Шинээр батлагдан орон нутагт эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд авч үзэхэд хуульд заасан зөвшөөрөл олгогдоогүй байхад улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж байна.	10
А.2.4. Хөрөнгө оруулалтын төсвийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлт гаргасан эсэх нь тодорхойгүй байна.	10
А.2.5. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлсэн байна.	11
Б.1. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛЖЭЭ.	11
Б.1.1. Орон нутагт эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний хувьд тайлант оны 1 улиралд багтаан эрх шилжүүлж, тендер шалгаруулалтыг богино хугацаанд зохион байгуулжээ. ...	11
Б.1.2. Тендерийн баримт бичгийг журмын дагуу боловсруулсан байна.....	12
Б.1.3. Сонгон шалгаруулалтыг явуулахдаа ил тод байдлыг хангаж олон нийтэд нээлттэй байдлаар зохион байгуулсан байна.	12
Б.2. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭХГҮЙ БАЙГААГААС ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА.....	13
Б.2.1. Барилга байгууламжийг холбогдох норм дүрэм, стандарт батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэж байгаа боловч олон жил он дамжин, төсөвт өртөг өсөж байна.....	13
Б.2.2. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд тусгагдан эрх шилжсэн их засварын төсөл, арга хэмжээ нь өмнөх онд бүрэн хэрэгжсэн байна.....	17
Б.2.3. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд тусгагдан эрх шилжүүлсэн тоног төхөөрөмж ангилалд хамаарах төсөл, арга хэмжээ орон нутагт хэрэгжээгүй байна.	17
Б.2.4. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд тусгагдан эрх шилжүүлсэн ТЭЗҮ ангилалд хамаарах төсөл, арга хэмжээ орон нутагт хэрэгжээгүй байна.....	17



Б.2.5. Он дамжсан дуусаагүй орхигдсон төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулах талаар шийдвэрлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.	17
Б.3. ТАЙЛАНТ ОНЫ ХУВЬД САНХҮҮЖИЛТИЙГ ОЛГОХДОО БОДИТ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭЭГҮЙ БАЙНА.	18
Б.3.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо гүйцэтгэгчээс ирүүлсэн гүйцэтгэлээр олгож байгаа боловч бодит хэрэгжилтийг үнэлэхгүй байна.	18
Б.3.2. Төсөл арга хэмжээний гэрээний хугацаа, санхүүжилтэд өөрчлөлт оруулж буй нь төслийг хэрэгжүүлснээр бий болох үр өгөөжийг сааруулж, хөрөнгө оруулалт чанаргүй болох нөхцөлийг бүрдүүлж байна.	19
Б.4. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	20
Б.4.1. Захиалагч, болон зохиогчийн зүгээс үе шатны хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч өмнөх онуудад хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний чанар байдал муу байна.	20
Б.4.2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын болон ТЭЗ-ийн дотоод хяналт хийгдээгүй байна.	20
Б.5. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТЭЭР ХҮЛЭЭН АВЧ БАЙНА.	21
Б.5.1. Төсөл, арга хэмжээг хүлээн авах комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэн хүлээн авчээ.	21
Б.5.2. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээг дүгнэж, гэрээний үүргийн биелэлтийг тооцсон байна.	21
Б.5.3. Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээг бүртгэлд бүрэн тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна.	21
В.1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХГҮЙ БАЙГАА ЗӨРЧИЛ ДАВТАГДАЖ БАЙНА.	22
В.1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний 28.9 хувь нь хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулахгүй байна.	22
В.1.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд төлөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.	22
В.2. ТАЙЛАНТ ОНД БАТАЛСАН 37 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЦААШИД ГАРАХ ҮР АШГИЙГ ТООЦООГҮЙ БАЙНА.	23
В.2.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр шинээр баталсан төсөл, арга хэмжээний 61.7 хувийг шууд худалдан авалтаар хэрэгжүүлжээ.	23
В.2.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөвт болон УТҮГ-т эрх шилжүүлж буй нь төсвийн зориулалт бусаар зарцуулж болзошгүй нөхцөл байдлыг бүрдүүлж байна.	24
В.2.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэхгүй олгож байна.	27
В.2.4. Төсөл арга хэмжээнд тавих хяналт хангалтгүй, үр дүнгүй байна.	27
В.2.5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хүлээн авах комисс хангалтгүй ажиллаж байна.	28
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:	28
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР:	31

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ**

АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	“Алсын хараа-2050”-д тусгагдсан байдал	7
Хүснэгт 2	“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан байдал	8
Хүснэгт 3	“Аймгийн бодлогын баримт бичиг”-т тусгагдсан байдал	9
Хүснэгт 4	ТЭЗҮ, зураг төсөв, техникийн нөхцөл өгөгдсөн байдал	10
Хүснэгт 5	Эрх шилжсэн болон тендер шалгаруулсан байдал	12
Хүснэгт 6	Сонгон шалгаруулалтад мөрдсөн журам болон зарласан хэлбэр	12
Хүснэгт 7	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламж	13
Хүснэгт 8	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн их засвар	17
Хүснэгт 9	Дуусаагүй орхигдсон төсөл, арга хэмжээ	18
Хүснэгт 10	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дуусаагүй төсөл арга хэмжээний гүйцэтгэл	18
Хүснэгт 11	Гэрээний нэмэлт өөрчлөлт	19
Хүснэгт 12	Үүрэг даалгаврын биелэлт	21
Хүснэгт 13	Нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал	22
Хүснэгт 14	Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичиг	22
Хүснэгт 15	Төсөл, арга хэмжээний ангилал	24
Хүснэгт 16	Хэрэгжиж дуусаагүй төсөл, арга хэмжээ	24
Хүснэгт 17	Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байдал	28

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Ээж уулийн отоглох цэг	14
Зураг 2	Халиун сумын бохир усны шугам сүлжээ	14
Зураг 3.	Халиун сумын цэвэрлэх байгууламж	15
Зураг 4.	Цээл сумын цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц	15
Зураг 5.	Есөнбулаг сумын 8 багийн тоглоомын талбай	15
Зураг 6.	Бигэр сумын спорт заалны барилга	15
Зураг 7.	Бугат сумын спорт заалны барилга	16
Зураг 8,	Есөнбулаг сумын 4 дүгээр сургуулийн спорт заалны барилга	16
Зураг 9	Цогт сумын Баянтоорой тосгоны спорт заал	16
Зураг 10	Тонхил сумын спорт заалны барилга	16
Зураг 11	Алтай сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөл	16
Зураг 12	Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын гадна тохижилт	25
Зураг 13	Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТУ-ын тоног төхөөрөмж	25
Зураг 14	Багш хөгжлийн ордон	26



Зураг 15.	Нийлүүлсэн хавтан	26
Зураг 16.	Баярхайрхан багийн 9 дүгээр гудамжны хайс	26
Зураг 17.	Естийн аманд хийгдсэн хайс	26
Зураг 18.	Услалтын систем	26
Зураг 19.	Есөнбулаг сумын 5 дугаар сургуулийн барилга	27
Зураг 20.	Хүлэмж	27

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн хийлээ.
Аудитын зорилго	“Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх • Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх • Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл үр дүнтэй хэрэгжсэн эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт эрх шилжүүлсэн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймгийн Засаг даргын тамгын газар, түүний харьяа газар хэлтэс, аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, төсөл арга хэмжээний ашиглагч байгуулагч, гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын холбогдох үйл ажиллагааг хамруулав.
Аудитын арга зүй	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000 стандартад нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817:2020, “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817:2020, Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” MNS 6817:2020, Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга



Аудитын шалгуур үзүүлэлт	лавлагаа, тодруулга болон судалгаа авах харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Аудитын асуудлын шинжилгээний асуултын дагуу арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон улс, орон нутгийн төсвийн санхүүжилтээр төсөл, арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: • Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль • Төсвийн тухай хууль • Төсвийн тогтвортой байдлын тухай хууль • Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль • Барилгын тухай хууль • Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал • Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 10 дугаар тогтоол "Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл" • Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол. "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" • Барилга байгууламжийн батлагдсан зураг, төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд
Аудитын баг, бүрэлдэхүүн	Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Ц.Сайханжаргал, М.Атарцэцэг, М.Дөлгөөнбаяр нар нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурал 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг баталжээ.

Говь-Алтай аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6,367.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээг эрх шилжүүлсэн байна. Батлагдсан арга хэмжээнд 2022 онд өмнөх оноос он дамжин үргэлжлэн хэрэгжиж буй 12, шинээр хэрэгжиж буй 4 төсөл, арга хэмжээ багтсан. Манай аймагт хэрэгжихээр батлагдсан нийт төсөл арга хэмжээний 75 хувийг барилга байгууламж, 25 хувийг их засварын төсөл арга хэмжээ эзэлж байна.

Эрх шилжиж ирсэн ажлаас 6 төсөл арга хэмжээг хүлээж авсан 10 төсөл арга хэмжээ нь хэрэгжиж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар "Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт"-аар 2 төсөл, арга хэмжээг



хэрэгжүүлэхээр 100.0 сая төгрөгөөр, 02 дугаар сарын 23-ны өдрийн 15 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар уг жагсаалтыг 18 төсөл, арга хэмжээг 1,423.0 сая төгрөгөөр, 06 дугаар сарын 13-ны өдрийн 37 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар 36 төсөл, арга хэмжээг 1,323.0 сая төгрөгөөр, 09 дүгээр сарын 16-ны өдрийн 54 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар 38 төсөл арга хэмжээг 1,323.0 сая төгрөгөөр, 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 63 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар 38 төсөл, арга хэмжээг 1,323.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тус тус баталсан байна.

Шилэн данс: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл¹, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Гэтэл тайлант онд эрх шилжин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 4,250.63 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 94.64 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээг мэдээлээгүй байна.

Удирдлагын систем: Сангийн яамнаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем www.publicinvestment.gov.mn веб хуудсыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгохоор арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Аудитаар Говь-Алтай аймагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний мэдээллийг тус цахим системд мэдээлсэн байдлыг шалгаж үзэхэд байршуулаагүй, ашиглалт хангалттай бус байна.

Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт: Төрийн аудитын байгууллагын статистик мэдээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтад хийсэн өмнөх онуудын аудитаар өгөгдсөн 15.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 2,293.4 сая төгрөгийн 6 албан шаардлага, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар өгсөн 7.16 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 32.3 сая төгрөгийн 9 албан шаардлага хэрэгжээгүй үлдэгдэлтэй байна. Эдгээрийг задалж үзвэл:

- 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 01/133 дугаартай төлбөрийн акттай холбоотой гомдлыг Цагдаагийн байгууллагад хандсан.
- 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 02/137 дугаартай төлбөрийн акттай холбоотой асуудлыг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан.
- 2022 оны 04 дүгээр сарын 01/116 дугаартай төлбөрийн актыг гүйцэтгэгч Сэрүүн Сайхан Алтай ХХК нь тайлант оны 5 дугаар сард төлөхөөр албан бичгийг ирүүлсэн.
- 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/188 дугаартай албан шаардлагаас 4 төсөл, арга хэмжээг дахин засварлуулахаар гүйцэтгэгчид хандсан, 1 гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцлахаар ажиллаж байгаа, 1 зөрчилд яамдад хандан албан бичгийг хүргүүлж ажиллаж байгаа боловч үр дүнд хүрээгүй байна.
- 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 03/188 дугаартай албан шаардлагын дагуу 1 гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн, 1 ажлыг 2022 онд гүйцэтгүүлэн хүлээж авсан.

¹ 6.9.Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвөө, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй.



- 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 03/189, 04/189, 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 01/196, 03/196, 05/196 06/196, 09/196, 10/196, 11/196, 13/196 дугаартай албан шаардлагатай холбоотойгоор гүйцэтгэгч нарт хандаж хүсэлт гаргасан.
- 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 06/189 дугаартай албан шаардлагатай холбоотой 1 зөрчилд 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж хандсан.
- 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 02/196 дугаартай албан шаардлагаас 1 зөрчлийг арилгуулж, 4 зөрчилд гүйцэтгэгчид шаардлага хүргүүлжээ.

Аймгийн Засаг даргаас шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахаар үе шаттай ажил зохион байгуулж гүйцэтгэгч болон хуулийн байгууллагад хандсан байх боловч үр дүн гараагүй. Аудитын байгууллагын шийдвэрийг цаг хугацаанд нь ханган хамтарч ажиллаагүйгээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнээс иргэд олон нийтийн хүртэх үр өгөөж буурах, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилт удаашрах улмаар нэгэнт эхэлсэн ажлын төсөвт өртөг өсөх, үр дүнгүй зардал гарах, гүйцэтгэгчтэй олон удаагийн гэрээ байгуулах гэх мэтээр төсвийн зардал нэмэгдэх шалтгаан болж байгааг онцгойлон анхаарч өгсөн шийдвэр болон түүний хэрэгжилтэд ач холбогдол өгч хамтарч ажиллах зайлшгүй шаардлага тулгарсан байна.

А.1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА.

А.1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 1 төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан үзэл санаатай нийцэхгүй байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд батлагдсан төсөл, арга хэмжээнээс Говь-Алтай аймагт шинээр батлагдсан 4, өмнөх оноос шилжих 12, нийт 16 төсөл, арга хэмжээг эрх шилжүүлсэн байна.

Эдгээр 4 төсөл арга хэмжээнээс 3 нь “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-той нийцжээ.

Харин Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум/ төсөл, арга хэмжээг шинэ суурьшлын бүсэд хэрэгжүүлж буй боловч нэгдсэн дулааны систем бус зөвхөн цэцэрлэг, соёлын төвийн халаалтын зуух байдлаар хэрэгжүүлж буй нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 9 дүгээр зүйлийн 9.3.3-т “Инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлсэн байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Хүснэгт 1. “Алсын хараа-2050”-д тусгагдсан байдал.

Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг сая.төг	Алсын хараа-2050
VI.1.16	БОАЖ С	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/	Барилга байгууламж	100.00	8.2.1 ²
XII.1.99	БХБС	Бохир усны шугам сүлжээ /Говь-Алтай, Халиун сум/	Барилга байгууламж	545.70	9.3.3 ³

² Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 8.2.1-т “Байгаль экологи, археологи, палеонтологи, нүүдлийн өв, түүх, соёл, рекреацийн нөөц, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлнэ.”

³ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 9.3.3-т “Инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлсэн байна”



XII.1.166	БХБС	Цэвэрлэх байгууламжийн барилга /Говь-Алтай, Халиун сум/	Барилга байгууламж	471.80	9.3.3
XII.1.169	БХБС	Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум /	Барилга байгууламж	357.00	

А.1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр тайлант онд батлагдсан 1 төсөл, арга хэмжээ нь "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-тэй нийцээгүй байна.

Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"⁴-ийг баталсан.

Говь-Алтай аймагт шинээр 2022 онд хэрэгжихээр баталсан 3 төсөл, арга хэмжээ нь дээрх үндсэн чиглэлтэй нийцсэн байна. Харин "Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум/" төсөл, арга хэмжээг тайлангийн А.1.1-т тусгасан шалтгаанаар нийцэхгүй байна гэж үзлээ.

Хүснэгт 2. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан байдал.

Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг сая.төг	Үндсэн чиглэл
VI.1.16	БОАЖ С	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/	Барилга байгууламж	100.00	8.2.1 ⁵
XII.1.99	БХБС	Бохир усны шугам сүлжээ /Говь-Алтай, Халиун сум/	Барилга байгууламж	545.70	9.3.3 ⁶
XII.1.166	БХБС	Цэвэрлэх байгууламжийн барилга /Говь-Алтай, Халиун сум/	Барилга байгууламж	471.80	9.3.3
XII.1.169	БХБС	Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум /	Барилга байгууламж	357.00	

А.1.3. Шинэ суурьшлын бүсэд баригдаж байгаа барилга байгууламжийн дэд бүтцийг бие даасан байдлаар шийдвэрлэж буй нь төлөвлөлтийг хийхдээ баримт бичгийн уялдааг хангахгүй байгааг илтгэж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 10 дугаар тогтоолын хавсралтаар "Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл", 11 дүгээр тогтоолын хавсралтаар "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг "Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"⁷-той нийцүүлэн баталсан байна.

Дээрх хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд Сумдын төвийг төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн системтэй болгохоор тусгасан⁸ байхад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум /" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан нь төлөвлөлтийн уялдаа хангагдахгүй байгааг илтгэж байна.

⁴ <https://legalinfo.mn/mn/detail/15584>

⁵ Монгол Улсын ИХ Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 8.2.1. аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн жуулчдын тоог нэг саяд хүргэнэ.

⁶ Монгол Улсын ИХ Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 9.3.3. инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлнэ.

⁷ <https://legalinfo.mn/mn/detail/15406>

⁸ Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 10 дугаар тогтоолын хавсралтын 8.1.2. Сумдын төвийг төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн системтэй болгоно.



Хүснэгт 3. "Аймгийн бодлогын баримт бичиг"-т тусгагдсан байдал /сая.төгрөг/

Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийн үндсэн чиглэл
VI.1.16	БОАЖС	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/	Барилга байгууламж	100.00	3.4.3 ⁹	4.2.4 ¹⁰
XII.1.99	БХБС	Бохир усны шугам сүлжээ /Говь-Алтай, Халиун сум/	Барилга байгууламж	545.70	6.4.1 ¹¹	8.4.4 ¹²
XII.1.166	БХБС	Цэвэрлэх байгууламжийн барилга /Говь-Алтай, Халиун сум/	Барилга байгууламж	471.80	6.4.1	8.4.4
XII.1.169	БХБС	Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум /	Барилга байгууламж	357.00	6.4.1	

А.2. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.**А.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламж нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой байна.**

Төсвийн тухай хууль¹³-д 4 дүгээр зүйлийн 4.1.24-т "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг" гэж тусгасан. Энэхүү заалтын хүрээнд авч үзвэл тайланд онд шинээр батлагдсан 4 төсөл, арга хэмжээ нь Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т заасан барилга байгууламж¹⁴ гэх тодорхойлолтод хамаарч байна.

Говь-Алтай аймагт хэрэгжүүлэхээр баталсан 4 төсөл, арга хэмжээний хувьд 3 нь тухайн шатны ЗДТГ-т, 1 нь цэцэрлэг, соёлын төвийн хөрөнгөд бүртгэх боломжтой байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан өөрчлөлтөөр Говь-Алтай аймагт хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээ байхгүй байна.

А.2.2. Орон нутагт уг асуудалд дүгнэлт өгөх боломжгүй байна.

⁹ Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралтын 3.4.3.Аялал жуулчлалын салбарын үйлчилгээний байгууллагуудын хүчин чадал, үйлчилгээг сайжруулж, жуулчдын амрах, үйлчлүүлэх ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

¹⁰ Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 10 дугаар тогтоолын хавсралтын 4.2.4.Аялал жуулчлалын салбарын үйлчилгээний байгууллагуудын хүчин чадал, үйлчилгээг сайжруулж, жуулчдын амрах, үйлчлүүлэх ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

¹¹ Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралтын 6.4.1. "Сумдын шинэчлэл-Хөдөөгийн хөгжил" төсөл хэрэгжүүлнэ.

¹² Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 10 дугаар тогтоолын хавсралтын 8.4.4.Алтай хотын цэвэрлэх байгууламжийг өргөтгөж, төв магистраль шугамыг шинэчлэх, сумдын төвийг усан хангамж, ариутгах татуургын нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттайгаар шийдвэрлэж, бага оврын цэвэрлэх байгууламжтай болгоно.

¹³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12254&type=2>

¹⁴ Барилгын тухай хуулийн 4.1.24 "барилга байгууламж" гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг, 4.1.28-т "засварын ажил" гэж барилгын үндсэн хийц, бүтээцийг өөрчлөхгүйгээр барилга байгууламжийг засварлах, түүнд суурилуулсан цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, механик тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг бууруулахгүйгээр ашиглалтын хугацааг уртасгах зорилгоор элэгдэж хуучирсан, эвдэрсэн тоног төхөөрөмжийг солих зэрэг үйл ажиллагааг,"



Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйл¹⁵-д заасны дагуу улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээг Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр тусгасан тул орон нутагт мэдээлэл байхгүй байна.

А.2.3. Шинээр батлагдан орон нутагт эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд авч үзэхэд хуульд заасан зөвшөөрөл олгогдоогүй байхад улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасан. Гэтэл “Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/”, “Бохир усны шугам сүлжээ /Говь-Алтай, Халиун сум/” 2 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын даалгавар, зураг төсөв хуульд тусгагдсаны дараа буюу 2022 онд боловсруулагдсан байна.

Харин “Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/”, “Цэвэрлэх байгууламжийн барилга /Говь-Алтай, Халиун сум/” төсөл, арга хэмжээний техникийн нөхцөл бүрэн олгогдоогүй байхад Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд тусгажээ.

Энэ нь тухайн төсөл, арга хэмжээ хэрэгжих хугацаа, чанар, санхүүжилтэд шууд нөлөөлж байна. Тухайлбал: 2020 онд хэрэгжүүлэхээр баталсан “Нийтийн тээврийн автобусны буудал, 10 байршил /ГАА Есөнбулаг/”¹⁶ төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хуульд заасан зөвшөөрөл олгогдоогүй байхад гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй байгаагаас дүгнэж болохоор байна.

Хүснэгт 4. ТЭЗҮ, зураг төсөв, техникийн нөхцөл өгөгдсөн байдал

Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Ажлын даалгавар	Зураг төсөв	Газрын зөвшөөрөл	Техникийн нөхцөл
VI.1.16	БОАЖС	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/	2022.02.21		2021.12.07	
XII.1.99	БХБС	Бохир усны шугам сүлжээ /Говь-Алтай, Халиун сум/	2022.02.24	2022.05.11	2021.12.07	2021.01.24
XII.1.166	БХБС	Цэвэрлэх байгууламжийн барилга /Говь-Алтай, Халиун сум/	2021.01.06	2022.01.20	2021.01.24	
XII.1.169	БХБС	Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум /	2020.04.16	2020.04.05	2019.02.20	2021.04.20

А.2.4. Хөрөнгө оруулалтын төсвийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлт гаргасан эсэх нь тодорхойгүй байна.

¹⁵ Төсвийн тухай хуулийн 28.3. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг дараах зүйлийг харгалзан тогтооно:

¹⁶ Шадар туслагч ХХК-тай 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан ЗТХЯ/202002071 дугаар гэрээ



Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4-т “Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх” гэж заасан бөгөөд урьдчилсан үнэлгээнд оруулах саналаа Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр баталсан. Аймгийн Засаг даргаас санал холбогдох байгууллагад хүргэсэн эсэх нь тодорхойгүй, ЗДТГ-аас баримт материалыг ирүүлээгүй болно.

А.2.5. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд орон нутагт эрх шилжиж ирсэн шинээр хэрэгжүүлж буй 4 төсөл, арга хэмжээ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл¹⁷д заасан шаардлагыг хангасан байна.

Харин 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.3, 13.4 дэх хэсгүүд нь 2023 оны төсөл, арга хэмжээнд хамаарах тул аудитаар авч үзсэнгүй.¹⁸

Тодруулга: Шилжин ирсэн төсөл, арга хэмжээ нь өмнөх оны аудитын тайланд тусгагдсан тул 1 дүгээр бүлэгт хамруулаагүй болно.

Б.1. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛЖЭЭ.

Б.1.1. Орон нутагт эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний хувьд тайлант оны 1 улиралд багтаан эрх шилжүүлж, тендер шалгаруулалтыг богино хугацаанд зохион байгуулжээ.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан өөрчлөлтөөр Говь-Алтай аймагт хэрэгжихээр батлагдсан Говь-Алтай аймгийн Засаг даргад эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээнээс 4 нь тайлант онд шинээр хэрэгжихээр батлагдаж, худалдан авах ажиллагааг зарлахаар байна. Төсөл, арга хэмжээг тайлант оны 1 дүгээр улиралд багтаан эрх шилжүүлж, сонгон шалгаруулалтыг явуулжээ.

Гэвч “Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум/” төсөл арга хэмжээ нь Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт¹⁹-ын XII.1.1.310-т тусгагдаж тус онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн А/63 дугаартай тушаалаар орон нутагт эрх шилжиж ирсэн байна. Үүний дагуу тус онд сонгон шалгаруулалтыг зохион байгуулан “Их морьт эрдэнэ” ХХК-тай 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдөр БСШУСЯ/202001052 дугаартай гэрээ байгуулжээ.

¹⁷ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.4.төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;

13.1.5.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх;

13.1.6.улсын болон орон нутгийн төсвийн эх үүсвэрээр барьж ашиглалтад оруулсан барилга байгууламжийн ашиглалтын хугацааны норм дуусахаас өмнө ижил төрлийн барилга байгууламж дахин шинээр барих төслийн санал гаргахгүй байх;

¹⁸ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 22.1.Энэ хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

22.2.Энэ хуулийн 13.3, 13.4 дэх хэсэг улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2023 оны төсвийн жилээс эхлэн шинээр тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хамаарна.

¹⁹ <https://old.legalinfo.mn/annex/details/10334?lawid=14829>



Гэтэл 2022 онд шинээр хэрэгжих барилга байгууламжийн жагсаалтад тусгагдаж дахин тендер шалгаруулсан нь шалтгаан тодорхойгүй байна.

Хүснэгт 5. Эрх шилжсэн болон тендер шалгаруулсан байдал

Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Эрх шилжсэн огноо	Үнэлгээний хороо байгуулсан огноо	Тендер зарласан огноо
VI.1.16	БОАЖС	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/	2022.02.14	2022.02.28	2022.02.28
XII.1.99	БХБС	Бохир усны шугам сүлжээ /Говь-Алтай, Халиун сум/	2021.12.01	2022.01.25	2022.01.27
XII.1.166	БХБС	Цэвэрлэх байгууламжийн барилга /Говь-Алтай, Халиун сум/	2021.12.01	2022.01.25	2022.01.25
XII.1.169	БХБС	Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум /	2020.02.04	2022.01.26	2022.01.28

Түүнчлэн Бохир усны шугам сүлжээ /Говь-Алтай, Халиун сум/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерт оролцогч “Эко буянт” ХХК гомдол гарган Сангийн яам хянаж дахин тендер зарласан бөгөөд дахин гүйцэтгэгчийг шалгаруулжээ.

Б.1.2. Тендерийн баримт бичгийг журмын дагуу боловсруулсан байна.

Сангийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 124 дүгээр тушаалаар харьцуулалтын аргаар бараа, ажил үйлчилгээ худалдан авах, 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 145 дугаар тушаалаар ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичгийг баталжээ.²⁰

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороонууд нь дээрх баримт бичгийн хүрээнд тендерийн баримт бичгийг боловсруулж батлуулсан байна.

Б.1.3. Сонгон шалгаруулалтыг явуулахдаа ил тод байдлыг хангаж олон нийтэд нээлттэй байдлаар зохион байгуулсан байна.

Тайлант хугацаанд сонгон шалгаруулалт явуулсан 4 төсөл, арга хэмжээний хувьд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7, 8 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтад заасан заасны дагуу босго үнийг баримтлан журмыг сонгожээ.

Түүнчлэн сонгон шалгаруулалтыг “Худалдан авах ажиллагааны цахим систем”²¹-ыг ашиглан зохион байгуулсан нь ил тод байдлыг хангасан байна.

Хүснэгт 6. Сонгон шалгаруулалтад мөрдсөн журам болон зарласан хэлбэр

Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Мөрдсөн журам	Зарласан хэлбэр	Зохион байгуулсан удаа
VI.1.16	БОАЖС	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/	100.00	Харьцуулалт	Цахим	3

²⁰ <https://www.tender.gov.mn/mn/document/list>

²¹ www.tender.gov.mn



XII.1.99	БХБС	Бохир усны шугам сүлжээ /Говь-Алтай, Халиун сум/	545.70	Нээлттэй	Цахим	1
XII.1.166	БХБС	Цэвэрлэх байгууламжийн барилга /Говь-Алтай, Халиун сум/	471.80	Нээлттэй	Цахим	1
XII.1.169	БХБС	Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум /	357.00	Нээлттэй	Цахим	2

Б.2. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭХГҮЙ БАЙГААГААС ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА.

Б.2.1. Барилга байгууламжийг холбогдох норм дүрэм, стандарт батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэж байгаа боловч олон жил он дамжин, төсөвт өртөг өсөж байна.

Тайлант оны Төсвийн хуульд батлагдаж орон нутагт эрх шилжиж ирсэн 16 төсөл, арга хэмжээнээс 12 нь барилга байгууламж байна.

Хүснэгт 7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламж

д/д	Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг сая.төг	Гэрээ байгуулсан огноо	Гэрээний хугацаа	Тайлбар
1	VI.1.16	БОАЖС	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/	100.00	2022.04.19	2022.04.19-2022.09.19	Хүлээж авсан
2	XII.1.99	БХБС	Бохир усны шугам сүлжээ /Говь-Алтай, Халиун сум/	545.70	2022.04.12	2022.04.12-2023.05.30	Гэрээний хугацаа дуусаагүй
3	XII.1.166	БХБС	Цэвэрлэх байгууламжийн барилга /Говь-Алтай, Халиун сум/	471.80	2022.03.18	2022.03.18-2023.07.15	Гэрээний хугацаа дуусаагүй
4	XII.1.169	БХБС	Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум /	357.00	2022.11.25	2022.11.25-2023.07.01	Гэрээний хугацаа дуусаагүй
5	XII.1.79	БХБС	Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт /Говь-Алтай, Есөнбулаг сум/	200.00	2020.08.21	2020.08.24-2020.10.15	Хүлээж авсан
6	III.1.1.10	МУЕС	Спорт заалны барилга /Говь-Алтай, Бигэр сум/	616.80	2019.10.09	2019.11.10-2022.10.15	Хугацаа дууссан
7	III.1.1.11	МУЕС	Спорт заалны барилга /Говь-Алтай, Бугат сум/	573.50	2019.12.18	2019.12.18-2022.12.01	Хугацаа дууссан
8	III.1.1.12	МУЕС	Спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/	980.00	2020.08.05	2020.08.05-2021.11.05	Хугацаа дууссан
9	III.1.1.13	МУЕС	Спорт заалны барилга /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/	702.70	2019.10.09	2019.10.10-2021.08.20	Хугацаа дууссан
10	III.1.1.23	МУЕС	Спорт заалны барилгын үлдэгдэл /Говь-Алтай, Тонхил сум/	359.90		2022.06.22-2022.12.31	Хугацаа дууссан
11	XV.3.1.2	ЗТХС	Нийтийн тээврийн автобусны буудал, 10 байрлал /Говь-Алтай, Есөнбулаг сум/	80.00	2020.11.20	2020.10.05-2021.08.20	Ажил зогссон.

12	XIX.1.44	ЭМС	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Говь-Алтай, Алтай сум/	250.00	2019.08.21	2019.09.04-2020.12.20	Хүлээж авсан
----	----------	-----	--	--------	------------	-----------------------	--------------

Хүснэгтээс авч үзэхэд дээрх 12 төсөл, арга хэмжээнээс 3 ажлыг хугацаанд нь хэрэгжүүлсэн, 3 төсөл арга хэмжээг анх төлөвлөхдөө 2023 онд үргэлжлэх гэрээ байгуулсан байна.

Нийтийн тээврийн автобусны буудал, 10 байрлал /Говь-Алтай, Есөнбулаг сум/ төсөл арга хэмжээ нь огт хэрэгжээгүй зогссон байна.

Харин Бигэр, Бугат, Есөнбулаг, Цогт сумын Баянтоорой тосгон, Тонхил сумдад хэрэгжиж буй спорт заалны барилгын ажлын гэрээний хугацаа дууссан байхад хүлээлгэн өгөөгүй, ажил дуусаагүй. Дээрх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу тооцож үзэхэд 384.98 сая төгрөгийн алданги тооцогдохоор байна.

Гэрээний хугацааг сунгасан төсөл, арга хэмжээний шалтгааныг задалж авч үзвэл:²²

- Гэрээний хугацаанд хэрэгжүүлэх боломжгүй болсон-2. (Спорт заалны барилга /Говь-Алтай, Бигэр сум/, Спорт заалны барилга /Говь-Алтай, Бугат сум/)
- Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалсан-3. (Спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/, Спорт заалны барилгын үлдэгдэл /Говь-Алтай, Тонхил сум/, Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Говь-Алтай, Алтай сум/)
- Санхүүжилт хугацаандаа олгогдоогүйгээс шалтгаалсан-2. (Спорт заалны барилга /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон, Нийтийн тээврийн автобусны буудал, 10 байрлал /Говь-Алтай, Есөнбулаг сум/)

Мөн барилга байгууламжид зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн байдлыг үзэхэд зөрчил илрээгүй, зураг төслийн дагуу гүйцэтгэсэн байх бөгөөд аудитаар дараах байдалтай байна. Үүнд:

1. Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээг “Алаг царам” ХХК гүйцэтгэж хугацаанд нь хүлээлгэн өгчээ. Ашиглалт хэвийн гэх тайлбарыг Цогт сумын ЗДТГ-аас ирүүлсэн.



Зураг 1.Ээж уулийн отоглох цэг

2. Бохир усны шугам сүлжээ /Говь-Алтай, Халиун сум/ төсөл, арга хэмжээг “Хонгор буурал” ХХК гүйцэтгэж байна. Гэрээний хугацаа дуусаагүй бөгөөд ажлын гүйцэтгэл 95 хувьтай, Халиун сумын ЗДТГ-аас гүйцэтгэгч ажлаа дуусгасан, хүлээж аваагүй байгаа гэх тайлбарыг өгсөн.



Зураг 2. Халиун сумын бохир усны шугам сүлжээ

²² Шалтгаан нөхцөлийг аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн, ашиглагч байгууллагын саналд тулгуурласан болно.

3. Цэвэрлэх байгууламжийн барилга /Говь-Алтай, Халиун сум/ төсөл арга хэмжээг “Жаргалант дулаан” ХХК гүйцэтгэж байна. Гэрээний хугацаа дуусаагүй бөгөөд 60 хувийн гүйцэтгэлтэй байна. Барилга байгууламж баригдсан.



Зураг 3.Халиун сумын цэвэрлэх байгууламж

4. Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум/ төсөл, арга хэмжээг “Их морьт Эрдэнэ” ХХК гүйцэтгэж байна. Гэрээний хугацаа дуусаагүй бөгөөд ажлын гүйцэтгэл 55 хувьтай.



Зураг 4.Цээл сумын цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц

5. Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт /Говь-Алтай, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээг “ЭСПМ Интернэйшнл” ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Ашиглалтад хүлээн авах комиссын үүрэг даалгавраар дулааны улиралд дутуу ажлыг хийхээр тохиролцсон. Аудитаар бодит байдалтай танилцахад “Баяншанд багийн тоглоомын талбайн шийдийн самбар, гэрлүүд хагарсан, хогийн сав болон сандлууд хөдөлгөөн орсон торон хашаа сэтэрсэн байх бөгөөд ашиглалтын явцад үүссэн байна.



Зураг 5.Есөнбулаг сумын 8 багийн тоглоомын талбай

6. Спорт заалны барилга /Говь-Алтай, Бигэр сум/ төсөл, арга хэмжээг “Залуур-Өргөө” ХХК гүйцэтгэж байна. Барилгын суурь тавигдаж карказ боссон байдалтайгаар барилгын ажил зогссон. Ажлын гүйцэтгэл 50 хувьтай.



Зураг 6. Бигэр сумын спорт заалны барилга

7. Спорт заалны барилга /Говь-Алтай, Бугат сум/ төсөл, арга хэмжээг “Аксу-Алтай” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 90 хувьтай байна. Барилгын үндсэн ажил дууссан дотор талын хамгаалалт хийгдээгүй байна. Аудитаар бодит хэрэгжилттэй танилцахад гадна талын чанар муутай материалаар хийгдсэн байна.



Зураг 7. Бугат сумын спорт заалны барилга

8. Спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээг “Сонгомол хаус констракшн” ХХК байгаа бөгөөд 40 хувийн гүйцэтгэлтэй байна. Барилгын суурь тавигдаж карказ боссон байдалтайгаар ажил зогссон.



Зураг 8. Есөнбулаг сумын 4 дүгээр сургуулийн спорт заалны барилга

9. Спорт заалны барилга /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/ төсөл, арга хэмжээг “Мөнхтооройт” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.



Зураг 9. Цогт сумын Баянтоорой тосгоны спорт заал

10. Спорт заалны барилгын үлдэгдэл /Говь-Алтай, Тонхил сум/ төсөл, арга хэмжээг “Хүрийн овоо” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. Аудитаар хэрэгжилттэй танилцахад цонхны хамгаалалт, халаалт, шал, хүзүүвч хийгээгүй байна. Резинен шалыг модон шалаар солих саналыг ашиглагч байгууллагаас тавьсан.



Зураг 10. Тонхил сумын спорт заалны барилга

11. Нийтийн тээврийн автобусны буудал, 10 байрлал /Говь-Алтай, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээг “Шадар туслагч” ХХК гүйцэтгэхээр 2020 онд гэрээ байгуулсан боловч санхүүжилт хүрээгүй гэх шалтгаанаар төсөв татагдаж ажил зогссон. Гэрээг цуцлахаар шийдвэрлэж байгаа гэх тайлбарыг аймгийн ЗДТГ-аас өгсөн.

12. Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Говь-Алтай, Алтай сум/ төсөл, арга хэмжээг “Сэрүүн сайхан Алтай” ХХК гүйцэтгэж 2021 онд хүлээлгэн өгсөн. Ашиглалт хэвийн, чанар байдал сайн.



Зураг 11. Алтай сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөл



Б.2.2. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд тусгагдан эрх шилжсэн их засварын төсөл, арга хэмжээ нь өмнөх онд бүрэн хэрэгжсэн байна.

Тайлант оны Төсвийн хуульд батлагдаж орон нутагт эрх шилжиж ирсэн 16 төсөл, арга хэмжээнээс 4 нь их засвар байна.

Эдгээр их засварууд нь 2021 онд бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд тайлант онд зөвхөн үлдэгдэл санхүүжилтийн олгожээ.

Хүснэгт 8. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн их засвар

д/д	Хуулийн дугаар	ТЭЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн сая.төг	Гэрээ байгуулсан огноо	Хүлээн авсан огноо
1	XIII.1.2.7	БШУС	Сургуулийн барилгын их засвар /Говь-Алтай, Төгрөг сум/	452.92	2021.06.30	2021.11.16
2	XIV.2.4	СоС	Соёлын төвийн барилгын их засвар /Говь-Алтай, Дэлгэр сум/	239.47	2021.06.25	2021.10.12
3	XIV.2.5	СоС	Соёлын төвийн барилгын их засвар /Говь-Алтай, Чандмань сум/	247.22	2021.08.24	2021.11.12
4	XIV.2.6	СоС	Соёлын төвийн барилгын их засвар /Говь-Алтай, Эрдэнэ сум/	147.41	2021.07.21	2021.10.09

Б.2.3. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд тусгагдан эрх шилжүүлсэн тоног төхөөрөмж ангилалд хамаарах төсөл, арга хэмжээ орон нутагт хэрэгжээгүй байна.

Б.2.4. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд тусгагдан эрх шилжүүлсэн ТЭЗУ ангилалд хамаарах төсөл, арга хэмжээ орон нутагт хэрэгжээгүй байна.

Б.2.5. Он дамжсан дуусаагүй орхигдсон төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулах талаар шийдвэрлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

Аудитаар тайлант хугацаанд болон өмнөх онуудын хуульд батлагдан хэрэгжиж байгаа орхигдсон төсөл, арга хэмжээний судалгааг гаргахад эрх шилжин хэрэгжиж байгаа чанар байдал ажлын гүйцэтгэл, төсвөөс шалтгаалан хэрэгжиж дуусаагүй 7 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- Ахмадын холбоо, сувиллын барилга /ГАА, Есөнбулаг сум/. Барилгын ажлын явцад магадлалын дүгнэлтээр гэрээ байгуулсан төсөвт өртөг 3 дахин өссөн дүнгээр хянагдсан бөгөөд тус нэмэгдсэн төсөв Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд батлагдаагүй, цаашид хэрхэн шийдвэрлэгдэх нь тодорхойгүйгээр ажил зогссон байна.
- Сумын төвийн шинэчлэл /ГАА, Дэлгэр сум/. Санхүүжилтийг бүрэн олгосон бөгөөд 2014 онд гэрээ байгуулж ажлыг үе шаттайгаар хүлээн авахаар шийдвэрлэсэн боловч хэрэгжиж дуусаагүй. Өнөөдрийг хүртэл төслийн үр ашгийг хүртээгүй.
- Соёл амралтын хүрээлэн байгуулах багц-3 /ГАА, Есөнбулаг сум/. ГААСДИХАШШ-ийн 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 133/ШШ2018/00567 дугаартай шийдвэрээр дутуу ажлыг гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн боловч өнөөдрийг хүртэл гүйцэтгэгч ажлаа хийгээгүй.
- Жишиг гудамж тохижилт /ГАА, Есөнбулаг сум/. Гүйцэтгэгчээс 2021, 2022 онд ажил хүлээлгэн өгөхөөр аймгийн ЗДТГ-т хандсан боловч чанар байдал муутай гэх шалтгаанаар хүлээж аваагүй байна.



- Цэцэрлэгийн барилга 100 ор /ГАА, Халиун сум/. Гүйцэтгэгч ажлаа хугацаандаа гүйцэтгэхгүй байсан тул БШУЯ-аас 2020.06.25-ны өдрийн 2/4250 дугаартай албан бичгээр гэрээг цуцалсан. Дахин гүйцэтгэгч сонгон шалгаруулахаар хүлээгдэж байгаа.
- Цэнгэлдэх хүрээлэн /ГАА, Есөнбулаг сум/. Төсөвт өртөг нэмэгдсэн бөгөөд төсөв Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд батлагдаагүй.
- Соёлын төвийн барилгын их засвар /Говь-Алтай, Хөхморьт сум/. Гүйцэтгэгчээс шалтгаалан ажил зогссон.

Хүснэгт 9. Дуусаагүй орхигдсон төсөл, арга хэмжээ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч	Төсөвт өртөг сая.төг	Олгосон санхүүжилт сая.төг	Ажлын гүйцэтгэл %
1	Ахмадын холбоо, сувиллын барилга /ГАА, Есөнбулаг сум/	"БГБС" ХХК	1,200.0	889.0	70%
2	Сумын төвийн шинэчлэл /ГАА, Дэлгэр сум/	"Мандал голомт" ХХК	5,000.0	5,000.0	50%
3	Соёл амралтын хүрээлэн байгуулах багц-3 /ГАА, Есөнбулаг сум/	"Ус-Алтай" ХХК	176.0	176.0	30%
4	Жишиг гудамж тохижилт /ГАА, Есөнбулаг сум/	"Бумбат даваа" ХХК	1,000.0	849.2	95%
5	Цэцэрлэгийн барилга 100 ор /ГАА, Халиун сум/	Баян Могод ХХК	1,166.3	666.3	30%
6	Цэнгэлдэх хүрээлэн /ГАА, Есөнбулаг сум/	Арвин бэлт ХХК	6,495.9	6,062.4	87.5%
7	Соёлын төвийн барилгын их засвар /Говь-Алтай, Хөхморьт сум/	"Аранжин Алтай" ХХК	220	160.4	70 %
			15,258,2		

Б.3. ТАЙЛАНТ ОНЫ ХУВЬД САНХҮҮЖИЛТИЙГ ОЛГОХДОО БОДИТ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭЭГҮЙ БАЙНА.

Б.3.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо гүйцэтгэгчээс ирүүлсэн гүйцэтгэлээр олгож байгаа боловч бодит хэрэгжилтийг үнэлэхгүй байна.

Захиалагчаас гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа санхүүжилтийг ажлын үе шатны гүйцэтгэлийн хувийг үндэслэн олгохоор тусгажээ.

Тайлант онд эрх шилжсэн 16 төсөл, арга хэмжээнээс 7 нь бүрэн хэрэгжсэн бол бусад төсөл арга хэмжээний гүйцэтгэл 10-95 хувьтай байна.

Хүснэгт 10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дуусаагүй төсөл арга хэмжээний гүйцэтгэл

д/д	Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг сая.төг	Гэрээний хугацаа	Хэрэгжилтийн хувь	Тайлбар
1	XII.1.99	БХБС	Бохир усны шугам сүлжээ /Говь-Алтай, Халиун сум/	545.70	2022.04.12 - 2023.05.30	95	Гэрээний хугацаа дуусаагүй
2	XII.1.166	БХБС	Цэвэрлэх байгууламжийн барилга /Говь-Алтай, Халиун сум/	471.80	2022.03.18 - 2023.07.15	60	Гэрээний хугацаа дуусаагүй
3	XII.1.169	БХБС	Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум/	357.00	2022.11.25 - 2023.07.01	55	Гэрээний хугацаа дуусаагүй



4	III.1.1.10	МУЕС	Спорт заалны барилга /Говь-Алтай, Бигэр сум/	616.80	2019.11.10 - 2022.10.15	50	Гэрээний хугацаа сунгасан.
5	III.1.1.11	МУЕС	Спорт заалны барилга /Говь-Алтай, Бугат сум/	573.50	2019.12.18 - 2022.12.01	90	Гэрээний хугацаа сунгасан.
6	III.1.1.12	МУЕС	Спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/	980.00	2020.08.05 - 2021.11.05	40	Гэрээний хугацаа сунгасан.
7	III.1.1.13	МУЕС	Спорт заалны барилга /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/	702.70	2019.10.10 - 2021.08.20	71	Гэрээний хугацаа сунгасан.
8	III.1.1.23	МУЕС	Спорт заалны барилгын үлдэгдэл /Говь-Алтай, Тонхил сум/	359.90	2022.06.22 - 2022.12.31	80	Гэрээний хугацаа сунгасан.
9	XV.3.1.2	ЗТХС	Нийтийн тээврийн автобусны буудал, 10 байрлал /Говь-Алтай, Есөнбулаг сум/	80.00	2020.10.05 - 2021.08.20	10	Ажил зогссон

Б.3.2. Төсөл арга хэмжээний гэрээний хугацаа, санхүүжилтэд өөрчлөлт оруулж буй нь төслийг хэрэгжүүлснээр бий болох үр өгөөжийг сааруулж, хөрөнгө оруулалт чанаргүй болох нөхцөлийг бүрдүүлж байна.

Тайлант онд тусгагдсан 7 төсөл, арга хэмжээний гэрээний заалтад өөрчлөлт оруулсан байна. Гэрээний нэмэлт өөрчлөлтийн авч үзвэл 2 төсөл, арга хэмжээний хугацаа, 5 төсөл, арга хэмжээний хугацаа болон санхүүжилт хамаарч байна.

Түүнчлэн Бигэр, Бугат, Есөнбулаг, Цогт сумын Баянтоорой тосгон, Тонхил сумын спорт заалны барилгын ажлын гэрээний хугацаа болон санхүүжилтэд 2022 онд Биеийн тамир, спортын улсын хорооноос өөрчлөлт оруулж нэмэлт гэрээг байгуулжээ. Ингэхдээ гэрээнд төсөвт өртөг нэмэгдсэн шалтгаан нөхцөлийг тодорхой тусгаагүй, орон нутагт цаашид дээрх төсөл, арга хэмжээтэй холбоотой гэрээний харилцаанд хэрхэн хандах нь ойлгомжгүй байдлыг үүсгэсэн байна.

Хүснэгт 11. Гэрээний нэмэлт өөрчлөлт

д/д	Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Анх байгуулсан гэрээний дүн /сая. төг/	Өөрчлөлт орсон гэрээний дүн /сая. төг/	Үнийн өсөлтийн хувь	Гэрээний хугацаа	Сунгалт хийсэн огноо
1	VI.1.1.6	БОА ЖС	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отогдох цэг /Улсын хэмжээнд/	99.00	0	0	2022.04.19-2022.07.19	2022.09.19
2	XII.1.79	БХБ С	Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт /Говь-Алтай, Есөнбулаг сум/	194.91	0	0	2020.08.24-2020.10.15	2022.10.15
3	III.1.1.10	МУЕ С	Спорт заалны барилга /Говь-Алтай, Бигэр сум/	250.00	616.77	59	2019.10.10-2019.12.20	2022.12.25
4	III.1.1.11	МУЕ С	Спорт заалны барилга /Говь-Алтай, Бугат сум/	250.00	573.55	56	2019.12.18-2020.08.01	2022.12.01
	III.1.1.12	МУЕ С	Спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/	250.00	577.36	57	2019.11.10-2021.11.05	2022.11.10



III.1.1 .13	МҮЕ С	Спорт заалны барилга /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/	247.47	702.74	65	2019.10.10- 2019.12.15	2022.11.10
III.1.1 .23	МҮЕ С	Спорт заалны барилгын үлдэгдэл /Говь-Алтай, Тонхил сум/	200.00	359.87	44	2018.09.20- 2018.11.23	2022.12.01

Б.4. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Б.4.1. Захиалагч, болон зохиогчийн зүгээс үе шатны хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч өмнөх онуудад хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний чанар байдал муу байна.

Тайлант хугацаанд хэрэгжиж байгаа 16 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад захиалагчийг төлөөлж аймгийн ГХБХБГ-аас үе шатны хяналтыг хэрэгжүүлсэн байна. Хэдийгээр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч төсөл, арга хэмжээний хэрэгжилт, чанар байдал хангалтгүй байгаа нь хяналт үр дүн багатай байна.

Аудитын явцад тайлант хугацаанд хамаарах болон өмнөх онуудад хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцтай танилцан холбогдох албан тушаалтнаас тодруулга авч үнэлэлт дүгнэлт өгсөн. Эдгээрээс доорх төсөл, арга хэмжээнүүдийг ажлын чанар байдлаас хамааран зайлшгүй дахин засварлах шаардлагатай байна. Үүнд:

- Чандмань сумын соёлын төвийн барилгын их засвар чанар байдал муутай хийгдсэн, будаг урсан.
- Багш хөгжлийн ордны цонх муу хийгдсэний улмаас шороо тоос их ордог, төв болон хойд хаалга зай ихтэй.
- Есөнбулаг сумын 2-р сургуулийн Спорт заалны барилгын хувцас солих өрөөний хананд цууралт үүссэн, гэрлийн бүрхүүлийн хамгаалалт муугаас хагарсан, агааржуулалтын сорогч ажиллахгүй байгаа.
- Төгрөг сумын сургуулийн барилгын дээврийн ус зайлуулах хаялага шаардлага хангахгүй, бороо, цасны ус гадна хана дагаж будаг, шохой урссан байдалтай байна.

Өмнөх оны аудитаар Захиалагчийн хяналтын дансны үлдэгдлийн тооцоог нийлж хяналттай зарцуулах талаар албан шаардлага өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй энэ хугацаанд дансны үлдэгдэлд тооцоо нийлж ажиллаагүй байлаа. Аудитын хугацаанд Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, ГХБХБГ хоорондыг өглөг авлагын тооцоо нийлж ирүүлэх талаар албан бичиг хүргүүлж тооцоог авсан боловч хариуцсан мэргэжилтнүүд удаа дараа солигдсоны улмаас бүрэн дүүрэн тооцоо нийлж чадахгүй нөхцөл байдалтай байна.

Захиалагчийн болон зохиогчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс орон нутагт хэрэгжсэн барилга угсралтын болон их засварын ажлын чанар ашиглалтын шаардлага хангаагүй, Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, норматив, стандарттай нийцэхгүй байна. Үүнд хөрөнгө оруулалтын мэргэжилтэн, барилгын хяналтын мэргэжилтэн тогтвор суурьшилтай ажиллахгүй олон дахин солигдож байгаа байдал мөн тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Б.4.2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын болон ТЕЗ-ийн дотоод хяналт хийгдээгүй байна.



Төсвийн тухай хуулийн 69.1²³, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тайлант хугацаанд хяналт шалгалт хийгээгүй байна. Харин Монгол Улсын Засгийн газраас хяналт шалгалт хийгдсэн эсэх нь тодорхойгүй байна.

Б.5. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТЭЭР ХҮЛЭЭН АВЧ БАЙНА.

Б.5.1. Төсөл, арга хэмжээг хүлээн авах комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэн хүлээн авчээ.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ыг баталж өгсөн. Уг дүрмийн дагуу аймгийн Засаг даргын захирамжаар комисс томилж байна. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс нь барилга байгууламжийг ашиглалтад оруулахтай холбоотой асуудлыг хуралдаанаар хэлэлцэн дүгнэлт гаргаж байна.

Тайлант онд хүлээн авсан 2 төсөл, арга хэмжээний хувьд авч үзэхэд “Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/”-г бүрэн хүлээж авсан бол “Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт /Говь-Алтай, Есөнбулаг сум/” төсөл, арга хэмжээг үүрэг даалгаврын биелэлтийн хуудсаар хүлээн авч дулааны улиралд дутуу ажлыг хэрэгжүүлэхээр тохиролцжээ.

Хүснэгт 12. Үүрэг даалгаврын биелэлт

Д/д	Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг сая.төг	Өгсөн үүрэг даалгавар	Биелсэн	Биелээгүй
1	VI.1.16	БОАЖС	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/	100.00	6	6	0
2	XII.1.79	БХБС	Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт /Говь-Алтай, Есөнбулаг сум/	200.00	12	8	4

Б.5.2. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээг дүгнэж, гэрээний үүргийн биелэлтийг тооцсон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/”, Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт /Говь-Алтай, Есөнбулаг сум/ 2 төсөл арга хэмжээг хүлээн авч гэрээг дүгнэж, гэрээний үүргийн биелэлтийг тооцсон байна.

Б.5.3. Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээг бүртгэлд бүрэн тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжиж ирсэн 16 төсөл арга хэмжээнээс өмнөх онд 5 төсөл арга хэмжээ, тайлант онд 2 төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авч ашиглагч байгууллагын бүртгэлд бүрэн тусгажээ. Тус төсөл арга хэмжээг ашиглагч байгууллага зориулалтын дагуу ашиглаж байна.

²³ 69.1-т Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.



Хүснэгт 13. Нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн сая.төг	Бүртгэлд тусгасан дүн	Бүртгэлд тусгасан байгууллага
1	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/	99.80	99.80	Цогт сумын ЗДТГ
2	Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт /Говь-Алтай, Есөнбулаг сум/	194.91	194.91	Есөнбулаг сумын ЗДТГ
3	Сургуулийн барилгын их засвар /Говь-Алтай, Төгрөг сум/	452.92	452.92	Төгрөг сумын сургууль
4	Соёлын төвийн барилгын их засвар /Говь-Алтай, Чандмань сум/	247.22	247.22	Чандмань Соёлын төв
5	Соёлын төвийн барилгын их засвар /Говь-Алтай, Дэлгэр сум/	239.47	239.47	Дэлгэр Соёлын төв
6	Соёлын төвийн барилгын их засвар /Говь-Алтай, Эрдэнэ сум/	147.41	147.41	Эрдэнэ Соёлын төв
7	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Говь-Алтай, Алтай сум/	250.00	250.00	Алтай сумын ЭМТ
		1631.73	1631.73	

В.1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХГҮЙ БАЙГАА ЗӨРЧИЛ ДАВТАГДАЖ БАЙНА.

В.1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний 28.9 хувь нь хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулахгүй байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 10 дугаар тогтоолоор “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл”, 11 дүгээр тогтоолын хавсралтаар “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 26 дугаар тогтоолоор “Аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-г тус тус баталсан.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд 38 төсөл, арга хэмжээг 1,323.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна.

Тус төсөл, арга хэмжээнээс 369.07 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээ нь “аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 460.27 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 төсөл арга, хэмжээ нь “аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл”, 596.71 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 15 төсөл, арга хэмжээ нь “аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-тэй нийцээгүй байна. Энэ нь нийт төсөл, арга хэмжээний 42.1 хувийг эзэлж байна.

Хүснэгт 14. Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичиг

д/д	Бодлогын баримт бичиг	Нийцсэн		Нийцээгүй	
		тоо	хувь	тоо	хувь
1	Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл	28	73.67	10	26.31
2	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	30	78.94	8	21.05
3	Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө	23	60.52	15	39.47

В.1.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд төлөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.



Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын бус шинж чанартай дэмжлэг, урсгалд зардалд 292.03 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24²⁴, 6 дугаар зүйлийн 6.4.1²⁵-т заасантай нийцэхгүй байна. Үүнд:

- Засагт хан аймаг, Хантайшир уулын аймаг болон Говь-Алтай аймгийн түүхтэй холбоотой судалгааны ажил
- "Гэгээн нуур Эрүүл ус" ОНӨААТҮГ газар татан буугдахтай холбоотой зардал
- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг дэмжих
- Галдан Бошгот хааны онгоныг тахиx хүндэтгэл ёслолын арга хэмжээний бэлтгэл ажил
- Хантайшир уулын аймгийн 100 жилийн ойн бэлтгэл ажлыг хангах хүрээнд
- Алтайн бренд бүтээгдэхүүнийг бий болгох, маркетинг сурталчилгаа
- Есөнбулаг сумын 8 байршилд мод тарих ажил

Түүнчлэн 26 төсөл, арга хэмжээг ажлын даалгаваргүй байхад баталсан, "108 сая мод тарих" арга хэмжээний хүрээнд Алтай хотын нисэх буудал чиглэлийн авто зам дагуу хашаа хайс хийх", "Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг дэмжих" төсөл, арга хэмжээний ажлын даалгаврыг 2022 онд боловсруулжээ.

Мөн "Инженерийн хийцтэй гүн өрмийн худгийн цооног гаргах", "Хөхморьт сумын шинэ сургууль, хуучин дотуур байрны ариун цэврийн байгууламжид худаг гаргах" төсөл арга хэмжээ нь газрын зөвшөөрөлгүй, "Ш.Батсуурь аваргын 100 жилд зориулсан музейн барилгын халаалтын холболт", "Инженерийн хийцтэй гүн өрмийн худгийн цооног гаргах", "Хөхморьт сумын шинэ сургууль, хуучин дотуур байрны ариун цэврийн байгууламжид худаг гаргах", "Багш хөгжлийн ордны гадна цэвэр, дулааны шугам сүлжээний угсралт", төсөл арга хэмжээ нь техникийн нөхцөл аваагүй байхад баталсан. Эдгээр үйл ажиллагаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4²⁶-т заасныг зөрчиж байна.

В.2. ТАЙЛАНТ ОНД БАТАЛСАН 37 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЦААШИД ГАРАХ ҮР АШГИЙГ ТООЦООГҮЙ БАЙНА.

В.2.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр шинээр баталсан төсөл, арга хэмжээний 61.7 хувийг шууд худалдан авалтаар хэрэгжүүлжээ.

Тайлант онд 21 төсөл, арга хэмжээг шууд худалдан авалтаар, 4 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтаар, 5 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар, 4 төсөл, арга хэмжээг зөвлөх сонгох шалгаруулалтаар худалдан авсан байна.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан 13 төсөл, арга хэмжээ буюу 34.2 хувьд нь худалдан авах ажиллагааг зарласан байна. Хэдийгээр шууд худалдан авалт хийсэн 21 төсөл, арга хэмжээ нь хуульд заасан босго үнэд төсөвт өртөг хүрээгүй боловч Төсвийн тухай хууль²⁷, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль²⁸-д заасан ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимтай нийцэхгүй байгааг цаашид харгалзан үзэх шаардлагатай байна.

Харин "Инженерийн хийцтэй гүн өрмийн худгийн цооног гаргах" 46.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга, хэмжээг шууд худалдан авалт хийсэн. Мөн "Алтай усан спорт

²⁴ 4.1.24. "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

²⁵ 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

²⁶ 29.4. Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

²⁷ 5.1.4. ил тод байдлыг хангасан байх;

²⁸ 6.1. Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.



чийрэгжүүлэлт” УТҮГ-т үйл ажиллагааны дэмжлэг 58.8 сая төгрөгийг шилжүүлсэн бөгөөд үүнээс 22.5 сая төгрөгөөр тоног төхөөрөмж бэлтгэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4²⁹, 8.5³⁰-т заасныг мөрдөхгүйгээр шууд худалдан авалт хийжээ.

В.2.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөвт болон УТҮГ-т эрх шилжүүлж буй нь төсвийн зориулалт бусаар зарцуулж болзошгүй нөхцөл байдлыг бүрдүүлж байна.

Говь-Алтай аймагт 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 38 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталж 86.8 хувь буюу 33-г нь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 15.Төсөл, арга хэмжээний ангилал

д/д	Төсөл, арга хэмжээний ангилал	Төлөвлөсөн		Хэрэгжүүлсэн	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Барилга байгууламж	3	7.89	2	66.67
2	Их засвар	3	7.89	3	100.00
3	Тоног төхөөрөмж	13	34.21	13	100.00
4	ТЭЗҮ	11	28.95	9	81.82
5	Бусад	8	21.05	6	75.00
Дүн		38	100	33	86.84

Үүнээс 8 төсөл арга хэмжээг эрх шилжүүлэн авсан этгээд нь өөрөө бэлтгэн нийлүүлж, бусад арга, хэмжээг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллажээ.

Аймгийн Засаг даргаас захирамжаар төсөвт байгууллага болон УТҮГ-т эрх шилжүүлж байгаа нь төсөл, арга хэмжээний үр дүн, чанар байдал доголдох, хяналтын тогтолцоог алдагдах сөрөг нөлөөтэй байна. Тухайлбал: “Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ-ын гадна тохижилт хийх” төсөл арга хэмжээгээр 7.5 сая төгрөгийн гадна тохижилтын хөрөнгө бэлтгэж нягтлан бодох бүртгэлд орлого авсан боловч бодитоор шалгахад уг хөрөнгө байхгүй, өөр зориулалтаар буюу байгууллагын дотоод заслыг хийж төсвийг зориулалт бусаар зарцуулжээ.

Тайлант онд хэрэгжүүлсэн 33 төсөл, арга хэмжээнээс 1,031.28 сая төгрөгийн санхүүжилтээр 27 нь бүрэн хэрэгжсэн бол 320.98 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 6 төсөл, арга хэмжээ нь хугацаа дуусаагүй 2023 онд үргэлжлэхээр гэрээтэй байна. Үүнд:

Хүснэгт 16.Хэрэгжиж дуусаагүй төсөл, арга хэмжээ

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн сая.төг	Гэрээний хугацаа		Олгосон санхүүжилт сая.төг	Гүйцэтгэлийн хувь
			Эхлэх	Дуусах		
1	Засагт хан аймаг, Хантайшир уулын аймаг болон Говь-Алтай аймгийн түүхтэй холбоотой судалгааны ажил	19.00	2022.10.03	2023.06.01	13.62	70
2	Гэр хорооллын дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээний холболтын	24.95	2022.06.09	2023.02.20	17.48	50

²⁹ 8.4.Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

³⁰ 8.5.Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

	зураг төсөл боловсруулах (Говь-Алтай, Есөнбулаг сум, Жаргалант баг)					
3	Хөхморьт, Чандмань сумын инженерийн шугам сүлжээнд холбох ажлын зураг төсөл (УХАТ, ЦДАШ, Холбоо дохиолол, ДДТ-ийн барилга, 5 хос шугам)	49.95	2022.06.09	2023.02.20	34.98	50
4	Хантайширын гудамжны явган хүний авто замыг өргөтгөн шинэчлэхэд шаардлагатай материал худалдан авах	50.00	2022.07.08	2023.06.01	25.00	50
5	Цогт сумын Төгрөг багийн засвар	10.00	2022.09.29	2023.06.20	10.00	60
6	8 байршилд мод усалгааны нөөцийн сав байршуулах	167.08	2022.11.18	2023.04.17	50.00	30
	Дүн	320.98			151.08	51.6

Мөн хэрэгжиж дууссан 27 төсөл, арга хэмжээнээс 12-н гэрээг дүгнэж хүлээж аваагүй байх бөгөөд 2 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг дутуу олгосон байна. Үүнд:

- Бигэр сумын хорооллын гадна цахилгааны дэд өртөө, шугам сүлжээний ажил. Үлдэгдэл санхүүжилт-44.31 сая төгрөг. (Комисс ажиллан үүрэг даалгавар өгсөн)
- Залуус цэцэрлэгт хүрээлэн, залуус гудамжны усалгааны систем. Үлдэгдэл санхүүжилт-3 сая төгрөг. (Хүлээж авсан)

Аудитаар зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилт бодит байдалтай түүвэрчлэн танилцахад дараах байдалтай байна. Үүнд:

1. Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТУГ-ын гадна тохижилт хийх. Гадна тохижилт хийхээр 19.2 сая төгрөгийг дэмжлэг авч 7.5 сая төгрөгийн гадна тохижилтыг хийснээр хөрөнгө бэлтгэж нягтлан бодох бүртгэлд орлого авсан боловч бодитоор шалгахад уг хөрөнгө байхгүй, өөр зориулалтаар буюу байгууллагын дотоод заслыг хийсэн.




Зураг 12. Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын гадна тохижилт

2. Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТУГ-т үйл ажиллагааны дэмжлэг. Үйл ажиллагааны дэмжлэг 58.8 сая төгрөгөөс өмнөх түрээслэгч байгууллагын хуучин тоног төхөөрөмжийг 18.5 сая төгрөгөөр, 7.0 сая төгрөгөөр тоос сорогч худалдан авч, 33.3 сая төгрөгийг байгууллагын урсгал зардалд зарцуулсан.



Зураг 13. Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТУ-ын тоног төхөөрөмж

3. Багш хөгжлийн ордны гадна цэвэр, дулааны шугам сүлжээний угсралт. "Моденс" ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Ашиглалт хэвийн, тус барилгад Есөнбулаг сумын 6 дугаар цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна.



Зураг 14. Багш хөгжлийн ордон

4. Хантайширын гудамжны явган хүний авто замыг өргөтгөн шинэчлэхэд шаардлагатай материал худалдан авах. “Моденс” ХХК эхний нийлүүлэх 50,000 ширхэг хавтанг хүлээлгэн өгсөн байна. Гэвч аудитаар бодит байдалтай танилцахад гүйцэтгэгч байгууллагын хашаанд 39,160 ширхэг хавтан тоологдож 10,840 ширхэг хавтан дутагдсан.



Зураг 15. Нийлүүлсэн хавтан

5. "108 сая мод тарих" арга хэмжээний хүрээнд Есөнбулаг сумын Баянхайрхан багийн 9-р гудамжны араар хашаа, хайс хийх. “Ком-Алтай” ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн боловч аудитаар танилцахад хайсны чанар байдал муутай байна.



Зураг 16. Баянхайрхан багийн 9 дүгээр гудамжинд хийгдсэн хайс

6. "108 сая мод тарих" арга хэмжээний хүрээнд Алтай хотын нисэх буудал чиглэлийн авто зам дагуу хашаа хайс хийх. “Гранд мөнх буурал” ХХК гүйцэтгэсэн бөгөөд чанар байдал сайн муутай боловч байршлыг сольсон байна. (Естийн гүүр Тайшир салдаг замын хажуу)



Зураг 17. Естийн амны хайс

7. Залуус цэцэрлэгт хүрээлэн, залуус гудамжны усалгааны систем. “Моденс” ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн бөгөөд байршил солигдон Солонго хорооллын дээд талын ногоон төгөл болон Усан спорт чийрэгжүүлэлтийн газарт хийгдсэн.



Зураг 18. Усгалтын систем

8. Есөнбулаг сумын 5-р сургуулийн дээврийн засвар. Иргэн З.Энхжаргал ахлагчтай иргэдийн бүлэг гүйцэтгэсэн боловч чанар байдал муу, дээврээс ус гоождог.



Зураг 19. Есөнбулаг сумын 5 дугаар сургуулийн барилга

9. Есөнбулаг суманд тохижилтын цэцэг тарих хүлэмж нийлүүлэх (6*10) 1ш. Хансан панзат ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Есөнбулаг сумын 11 дүгээр цэцэрлэг ашиглаж байна.



Зураг 20. Хүлэмж

Харин орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө үр ашгийг тооцоогүй тул төсөл, арга хэмжээний орон нутгийн хөгжил, нийгэм, эдийн засаг, ажлын байр нэмэгдүүлсэн байдлыг үнэлэх боломжгүй байна.

В.2.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэхгүй олгож байна.

Тайлант онд хэрэгжсэн 33 төсөл, арга хэмжээнээс 17 төсөл, арга хэмжээний 442.1 сая төгрөгийн санхүүжилтийг шууд олгожээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6³¹, 41.2.7³²-т заасантай нийцэхгүй, төсөл, арга хэмжээ үр дүнгүй, чанар байдал муутай хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэхээр байна.

Түүнчлэн 48,5 хувь буюу 16 төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэж хугацаа хоцорч хүлээлгэн өгсөн 2 төсөл, арга хэмжээнээс 0.02 сая төгрөгийн алдангийг суутган тооцжээ.

Гэвч аудитаар давтан тулгахад Есөнбулаг сумын гэр хорооллын дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээний холболтын зураг төсөл боловсруулах", "Хөхморьт, Чандмань сумын инженерийн шугам сүлжээнд холбох ажлын зураг төсөл" төсөл арга хэмжээний гэрээний хугацаа дууссан боловч ажиллаа дуусаагүй, хүлээлгэж өгөөгүй. Дээрх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу тооцож үзэхэд 0.77 сая төгрөгийн алданги нэмж тооцогдохоор байна.

В.2.4. Төсөл арга хэмжээнд тавих хяналт хангалтгүй, үр дүнгүй байна.

Тайлант онд хэрэгжсэн 33 төсөл, арга хэмжээнээс 8 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлж, 25 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 8 төсөл арга хэмжээнээс аудитын явцад 6 төсөл арга хэмжээний бодит байдлыг шалгахад Есөнбулаг сумын 5-р сургуулийн дээврийн засварын ажил муу хийгдсэнээс дээврээс хана дагаж ус урссан, Есөнбулаг сумын 8 байршилд мод тарих ажлаар хийгдэх мод тарих шороог дутуу буулгасан зөрчил илэрлээ.

³¹ 41.2.6.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх;

³² 41.2.7.хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.



Зохиогчийн хяналтыг 4 төсөл арга хэмжээнд хэрэгжүүлэхээс 2 төсөл арга хэмжээнд хяналт хийгдэж “Бигэр сумын хорооллын гадна цахилгааны дэд өртөө, шугам сүлжээний ажил”, “Багш хөгжлийн ордны гадна цэвэр, дулааны шугам сүлжээний угсралт” төсөл арга хэмжээнд хяналт хийгдээгүй байна.

Мөн ТЕЗ-ын дэргэдэх дотоод аудитын нэгжээс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

В.2.5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хүлээн авах комисс хангалтгүй ажиллаж байна.

Тайлант онд хэрэгжсэн 33 төсөл, арга хэмжээнээс 27 төсөл арга бүрэн хэрэгжиж үүнээс 20 төсөл арга хэмжээнд ашиглалтад оруулах комисс томилогдон ажиллажээ.

Аудитын явцад төсөл арга хэмжээг хүлээн авсан ажлуудаас үзэхэд комисс ажиллаж бүрэн хэрэгжсэнээр акт үйлдэж хүлээн авсан ажлаас дараах зөрчлүүд илэрсэн.

- ❖ "Есөнбулаг сумын 8 байршилд мод тарих ажил" төсөл, арга хэмжээг хүлээн авах комисс ажиллаж бүрэн хэрэгжсэнээр хүлээн авсан боловч ажлын даалгавраас 26 машин бор шороо, элс бууц буулгаж, 24 машин материалыг буулгаагүй байхад хүлээж авсан
- ❖ "Хантайширын гудамжны явган хүний авто замыг өргөтгөн шинэчлэхэд шаардлагатай материал худалдан авах" төсөл арга хэмжээгээр 50,000 ширхэг замын хавтан нийлүүлэхээс бодитоор шалгахад гүйцэтгэгч байгууллагын хашаанд 39,160 ширхэг хавтан тоологдож 10,840 ширхэг хавтан дутсан байхад хүлээж авсан.
- ❖ "108 сая мод тарих" арга хэмжээний хүрээнд Есөнбулаг сумын Баянхайрхан багийн 9-р гудамжны араар хашаа, хайс хийх" хайсны чанар байдал муу, шон хоорондын зайг багасгах, шон суулгалтын гүний хэмжээг нэмэгдүүлэх үүрэг даалгаврын биелэлт өгсөн боловч хангагдаагүй байхад хүлээж авсан.
- ❖ "Есөнбулаг сумын 5-р сургуулийн дээврийн засвар"-ын ажил нь бороо, цасны ус дотор хана дагаж урссан, чанар муутай байхад хүлээж авсан.

Бүрэн хэрэгжиж хүлээж авсан 27 төсөл, арга хэмжээнээс 24 төсөл арга хэмжээг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгасан, 3 төсөл арга хэмжээг бүртгэлд тусгаагүй байна.

Хүснэгт 17. Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байдал

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн сая.төг	Бүртгэлд тусгаагүй дүн
1	"108 сая мод тарих" арга хэмжээний хүрээнд Алтай хотын нисэх буудал чиглэлийн авто зам дагуу хашаа хайс хийх	117.90	117.90
2	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг дэмжих	49.90	49.90
3	Залуус цэцэрлэгт хүрээлэн, залуус гудамжны усалгааны систем	10.00	10.00
		177.8	177.8

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БАЙГААГААС ШАЛТГААЛАН ОРОН НУТАГТ ҮҮСЭХ ҮР ӨГӨӨЖ БУУРЧ, ОН ДАМЖИН ХЭРЭГЖИЖ БАЙНА.



Дүгнэлтэд үндэслээд Үндэсний аудитын газарт нэгдсэн тайланд тусгуулах 1,859.48 сая төгрөгийн 5 санал, аймгийн Засаг даргад 2 заалт бүхий зөвлөмж, 911.92 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 14.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, аймгийн Татварын хэлтэст 31.5 сая төгрөгийн албан шаардлагыг тус тус хүргүүлээ.

Үндэсний аудитын газарт уламжлах санал:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ батлагдаж буй асуудлыг нэгдсэн тайланд тусгах.
- Өмнөх онд эрх шилжүүлсэн Бигэр, Бугат, Есөнбулаг, Цогт сумын Баянтоорой тосгон, Тонхил сумдын спорт заалны барилгын ажлын гэрээний хугацаа дууссан хүлээлгэн өгөөгүй, ажил дуусаагүй бөгөөд 2022 онд Биеийн тамир, спортын улсын хорооноос гэрээний хугацаа болон санхүүжилтэд өөрчлөлт оруулж байгуулсан нь орон нутагт цаашид дээрх төсөл, арга хэмжээтэй холбоотой гэрээний харилцаанд хэрхэн хандах нь ойлгомжгүй байдлыг үүсгэсэн байна. Мөн дээрх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу тооцож үзэхэд 339.25 сая төгрөгийн алданги тооцогдохоор байгааг холбогдох төсөв захирагчид уламжлах.
- Ахмадын холбоо, сувиллын барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/, Сумын төвийн шинэчлэл /ГАА, Дэлгэр сум/, Соёл амралтын хүрээлэн байгуулах багц-3 /ГАА, Есөнбулаг сум/, Жишиг гудамж тохижилт /ГАА, Есөнбулаг сум/, Цэцэрлэгийн барилга 100 ор /ГАА, Халиун сум/, Цэнгэлдэх хүрээлэн /ГАА, Есөнбулаг сум/, Соёлын төвийн барилгын их засвар /Говь-Алтай, Хөхморьт сум/-ийн 15,258.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээ нь өмнөх онуудад хэрэгжиж байсан боловч Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд батлагдаагүй, цаашид хэрхэн шийдвэрлэгдэх нь тодорхойгүйгээр ажил зогссон байгааг нэгдсэн тайлант тусган шийдвэрлүүлэх.

Аймгийн Засаг даргад өгөх зөвлөмж:

- Аймгийн дунд болон богино хугацааны хөгжлийн баримт бичигтэй нийцээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх

Аймгийн Засаг даргад өгөх албан шаардлага:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтын бус шинж чанартай, урсгал зардалд зарцуулахаар төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байх
- Төлөвлөлтийн шаардлага хангаагүй, үр ашгийн тооцоо хийгдээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж санхүүжүүлэхгүй байх.
- Босго үнээс төсөвт өртөг давсан төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалтыг журмын дагуу явуулах.
- Эрх шилжүүлсэн этгээд өөрөө бараа, ажил үйлчилгээ бэлтгэн нийлүүлж буй асуудлыг таслан зогсоох, хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд дотоод хяналтыг хийх.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системийн ашиглалтыг сайжруулан мэдээллийг бүрэн байршуулах
- Гэрээнд заасан хугацаанд ажлаа хүлээлгэн өгөөгүй, тайлант болон өмнөх онд чанар байдал муутай төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт хийж шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл”-д бүртгүүлэх
- Гүйцэтгэгч ажлын даалгавар, гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй байхад төсөл, арга хэмжээг хүлээн авсан болон захиалагчийн хяналтыг үр нөлөөгүй гүйцэтгэсэн албан тушаалтан нарын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж хариуцлага тооцох.
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсан улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг цаг хугацаанд нь бүрэн мэдээлэх



- Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй 177.8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд бүртгэх.

Аймгийн Татварын хэлтэст өгөх албан шаардлага:

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Говь-Алтай аймагт төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч татварын нэвтрэлтийн нэгдсэн системд төлбөрийн баримт шивээгүй аж ахуйн нэгжүүдэд хяналт хийх.

Аймгийн Засаг даргад төлбөрийн акт:

- Захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй 14.4 сая төгрөгийн үлдэгдлийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР:

Шалгагдагч байгууллагаас тайлангийн төсөлд саналгүй гэсэн хариуг албан бичгээр ирүүлсэн.



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг, 82093
Утас/Факс: 7048-4042, Цахим шуудан: info@govi-altai.gov.mn

2023.04.20 № 3/653

танай _____ -ны № _____ -т

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Улсын болон орон нутгийн төсвийн 2022 оны гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайланд тусгах санал байхгүй болно.

Өмнөх оны шийдвэрүүдийн хэрэгжилтийг хүргүүлж байна. Биелэлтээр тооцож өгнө үү.

Хавсралт /... хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ЭРДЭНЭБАТ

0208000761

[illegible]



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Харилцах хаяг:



**Хөгжил хороолол 1402, Жинст баг, Есөнбулаг сум,
Говь-Алтай аймаг, Монгол улс.**

Утас: 7048-4030

E-mail: govialtai@audit.gov.mn